



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№120 /564/

2023.08.04

Цаг үе, үйл явдал

КАТАР УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИНТЭЙ ХАМТАРСАН “ШИЙДЭМГИЙ ШИЙДВЭР-2023” АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨВ



Хоёр улсын батлан хамгаалах салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх зорилго бүхий Катар Улсын Зэвсэгт хүчинтэй хамтарсан 10 дахь удаагийн “Шийдэмгий шийдвэр” сургууль амжилттай болж өндөрлөлөө.

20 хоногийн хугацаанд үргэлжилсэн сургуульд Катар Улсын Зэвсэгт хүчнээс 450 (сонсогч 260), Монгол Улсаас Зэвсэгт хүчний 150 болон 311 дүгээр ангийн 170 гаруй цэргийн алба хаагч оролцсон юм.

Хамтарсан сургуулиар Катар Улсын “Ахмед Бин Мохаммедын” цэргийн коллежийн 4-р дамжааны сонсогч нар нь салаа, тасгийн

байлдааны боломжийг тодорхойлох, аяны толгойн хаалтад томилогдсон салааны ажиллагааг төлөвлөн удирдах, дайрах, туршуул үйлдэх, хорлон сүйтгэх, эргүүлийн бүлгийг томилон ажиллуулах, байлдан тагнах, хот дотор байлдааны ажиллагаа төлөвлөн зохион байгуулах зэрэг ажиллагаанд өөр өөр цагийн байдлууд дээр өөрсдийн цэргийн хэргийн мэдлэг, дадлага чадвараа нэмэгдүүлж, онолоор судалж мэдсэн мэдлэгээ газар орон дээр бататгасан юм.

Хаалтын үйл ажиллагааны үеэр Монгол Улсын Зэвсэгт хүчний ТХЦ-ийн командлагч бригадын генерал Б.Баатар хэлсэн үгэндээ хоёр

орны дипломат харилцаа, тэр дундаа батлан хамгаалах салбар хоорондын хамтын ажиллагааны бэлэг тэмдэг болсон 10 дахь удаагийн “Шийдэмгий шийдвэр” сургууль амжилттай болж өндөрлөсөнд баяртай байгаагаа онцлоод ирээдүйд офицер болохоор бэлтгэгдэж буй “Ахмед Бин Мохамед” цэргийн сургуулийн сонсогчдод тус сургуулиар олж авсан цэргийн хэргийн мэдлэг, ур чадвараа улам хөгжүүлж, даян дэлхийн энх тайвны төлөө харамгүй зориулна гэдэгт эргэлзэхгүй байгаагаа илэрхийлэв.

Дэслэгч
Ө.НАСАНТОГТОХ



ЗАЛУУ ОФИЦЕРУУДЫН ЧУУЛГАНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ДЭД АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын Залуу офицеруудын чуулганыг 9 дүгээр сарын 8-наас 10-ны өдрүүдэд зохион байгуулна.

Энэхүү чуулганыг угтаж энэ оны 2 дугаар сард Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг томилогдож, өнгөрсөн хугацаанд олон ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн, үр дүнд хүрээд байна.

Эл хугацаанд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага бүр Залуу офицеруудын дэд чуулганыг зохион байгуулаад байгаа юм.

Уг дэд чуулганыг Зэвсэгт хүчний хэмжээнд зохион байгуулах асуудлаар ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн хуралдааныг өнөөдөр буюу 8 дугаар сарын 4-ний

өдөр зохион байгууллаа.

Энэхүү хуралдаанаар төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын Залуу офицеруудын чуулганы ерөнхий зохион байгуулалтыг танилцуулснаас гадна Зэвсэгт хүчний Залуу офицеруудын дэд чуулганыг зохион байгуулах, Зэвсэгт хүчний шилдэг офицерыг шалгаруулах зэрэг асуудлыг хэлэлцлээ.

Хуралдаанаар 8 дугаар сарын 8-10-ны өдөр Зэвсэгт хүчний шилдэг офицерыг шалгаруулах уралдааныг дүгнэж тодруулах бөгөөд 20-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний Залуу офицеруудын дэд чуулганыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулахаар тогтлоо.

Хурандаа
Б.ОТГОНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ УР ЧАДВАРЫГ ӨНДРӨӨР ҮНЭЛЭВ



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд АНУ-ын Батлан хамгаалахын сайд Л.Остин наймдугаар сарын 3-ны өдөр бараалхаж, хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ АНУ-ын Засаг захиргаа Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхийг бэхжүүлэх, цаашид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд дахь Монгол Улсын оролцоог

нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлэв.

Батлан хамгаалахын сайд Л.Остин Монгол Улсын олон улсын болон НҮБ-ын энхийг сахиулах үйл хэрэгт оруулж байгаа хүчин чармайлт, Монголын Зэвсэгт хүчний ур чадварыг өндөрөөр үнэлж, АНУ-ын энхийг сахиулагчидтай Афганистан, Ирак улсад олон жилийн турш мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэсэнд талархал илэрхийлэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
17	9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	20

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,460	3,471
EUR	3,791	3,810
CNY	483	487
RUB	36.90	37.40
JPY	24.10	24.20
KRW	2.65	2.68

ЗУРХАЙ

2023.08.04 /БААСАН ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 18

ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ
САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР
ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:
Эд малын гарлагатай
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.32-20.25
Барилдлага:
Түлэх
Шүтэн барилдлага:
Төрөн түгэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,890,532

Эдгэрсэн

Нийт: 664,701,548

Нас барсан

Нийт: 6,904,302

Цахим шууданд

ГАМШИГ ОСЛЫН ҮЕД АВАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ОЙЛГУУЛАВ

Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн Сургалтын төвийн "Оюутан цэрэг" цэргийн мэргэжил олгох сургалтаар дайчдын хувь хүний хүмүүжил, хариуцлагатай иргэн болж төлөвших чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зарим сургалтыг зохион байгуулж байна. Хилийн цэргийн 0132 дугаар ангиас хошууч Ц.Ганхуяг хил хамгаалах байгууллагын замнал түүх, хөгжил, хилийн өнөөгийн нөхцөл байдлын мэдээлэл хүргэж, оюутан цэргүүдтэй нас чацуу залуус эх орныхоо торгон хилийн эмжин хамгаалж явааг тодотголоо.



Мөн энэ сарын 04-ний өдөр Дорнод аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга, хошууч Б.Цогтбаатар нарын албаныхан газар хөдлөлт, гамшиг ослын үед ямар хариу арга хэмжээ авах талаар сургалт явуулж, хүн нэг бүрт чиглэсэн дадлагыг гүйцэтгүүллээ. Түүнчлэн үер ус, гал түймрийн аюулаас өөрийгөө болоод нөхрөө хэрхэн аюул, осолгүй аврах талаар мэдээлэл хүргэж, хариуцлагатай иргэн болохын тулд хэзээд эрүүл, аюулгүй байдлаа хангаж байх ёстойг онцоллоо.

Ахлах дэслэгч Х.ГАРЬД



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ГУРВАН АЛБА ХААГЧ ГАЛ ГОЛОМТОО БАДРААЛАА



Цэргийн алба хаагчдын гэр бүлийн хөгжлийг дэмжих, залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 439 дүгээр хаалттай хорих ангийн санаачилгаар Орхон аймгийн Гэрлэх ёслолын газартай хамтран алба хаагчдын "Хуримын ёслол"-ын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Энэхүү ёслолд нийт 3 алба хаагч, тэдний гэр бүл, эцэг эх, үр хүүхэд, төрөл төрөгсөд болон тус байгууллагын алба хаагчдын төлөөлөл оролцож гэгээ цацарсан сүүн цагаан хуримын ажиллагааг нь гэрчиллээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага



Гэрэл зураг түүх өгүүлнэ



МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ

БОКСЫН ТЭМЦЭЭНД 118 ТАМИРЧИН ОРОЛЦОЖ, ШИЛДГЭЭ ТОДРУУЛЛАА



"Алдар" спорт хорооны боксын дасгалжуулагч агсан, спортын мастер, дэд хурандаа Хорлоогийн Магваны нэрэмжит боксын тэмцээн өнөөдөр "Алдар" спорт хорооноос зохион байгууллаа. Бага нас, өсвөр, залуучуудын ангиллаар зохиогдсон энэхүү тэмцээнд 22 байгууллагын 118 тамирчин өрсөлдсөн бөгөөд Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр, Баян-Өлгий, Өвөрхангай аймгийн өсвөр, залуу боксчид, Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг спорт хороод, клубүүдийн тамирчид оролцлоо. Спортын мастер Х.Магван агсан 1982-1999 оныг хүртэл "Алдар" спорт хорооны боксын дасгалжуулагчаар ажилласан ба "Алдар"-ын боксчид түүний удирдлага дор Монголын бүх ард түмний спартакиадад 11 удаа түрүүлж, хоёр удаа дэд байрт шалгарч байсан юм.



Бага нас – 30кг (11-12 нас)

1. Б.Энхдүүрэн (Дорноговь)
Хөвгүүд бага нас – 36кг (11-12 нас)
2. Н.Сүлд (Паувер Ап)
Хөвгүүд бага нас – 40кг (11-12 нас)
3. Ө.Сүлд (Алдар)
Хөвгүүд өсвөр үе – 34кг (13- 14нас)
4. Б.Сайханбилэг (Алдар)
Хөвгүүд өсвөр үе – 46кг (13- 14нас)
5. Б.Агарзандан (Радианс)
Хөвгүүд өсвөр үе – 48кг (13- 14нас)
6. А.Өрнөх (Ихэр бээлий)
Хөвгүүд өсвөр үе – 50кг (13- 14нас)
7. С.Ирмүүн (Алдар)
Хөвгүүд өсвөр үе – 63кг (13- 14нас)
8. Т.Даваажав (Ихэр бээлий)
Охид – 42кг (13-14 нас)
9. А.Мөнгөнзул (Ихэр бээлий)
Охид – 48кг (13-14 нас)
10. А.Аминаа (Радианс)
Хөвгүүд өсвөр үе – 52кг (15- 16нас)
11. Т.Цогтсайхан (Ихэр бээлий)
Хөвгүүд өсвөр үе – 54кг (15- 16нас)
12. Б.Анар (Ихэр бээлий)
Хөвгүүд өсвөр үе – 57кг (15- 16нас)
13. Б.Мөнхбаяр (Алтан бээлий)
Залуучууд - 54кг (17-18нас)
14. Х.Дөлгөөнсайхан (Алдар)
Залуучууд - 57кг (17-18 нас)
15. О.Энх-Ирээдүй (Алдар)

ТУСГАЙ ШАГНАЛ:

1. Шилдэг техниктэй боксчин эрэгтэй – Б.Сайханбилэг (Алдар)
 2. Шилдэг техниктэй боксчин эмэгтэй – А. Аминаа (Радианс)
 3. Шилдэг дайчин боксчин – Ө.Сүлд (Алдар)
 4. Шилдэг дайчин боксчин – Б.Тэмүүлэн (Монголын боксын академи)
 5. Шилдэг өсөх ирээдүйтэй боксчин – Л.Пүрэвдулам (Хар хорин)
- 23 БАЙГУУЛЛАГЫН 118 БОКСЧИН ОРОЛЦСОН, БАГИЙН ДҮН:
1. Алдар спорт хороо - 80,0 оноогоор I байр
 2. "Ихэр бээлий" боксын клуб - 48,5 оноогоор II байр
 3. "Радианс" боксын клуб - 38,0 оноогоор III байр тус тус эзэллээ.

Ахмад Ж.ОТГОНБАЯР

